



**НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/29

Улаанбаатар хот

**Шинэ коронавирусын халдвараас урьдчилан
сэргийлэх өндөржүүлсэн бэлэн байдлын
горимд шилжүүлэх тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Бэлэн байдлын зэрэг бууруулах тухай" 194 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1280 дугаар захирамж, Нийслэлийн Онцгой комиссын даргын баталсан "Хязгаарлалт тогтоохгүй үйл ажиллагаанд мөрдөх халдвар хамгааллын нийтлэг заавар", төвийн даргын 2019 оны А/10 тоот тушаалаар баталсан "Нийгмийн хамгааллын тусгай төвийн хөдөлмөрийн дотоод журам"-ын 4.5, 10.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажиллах тусгай горимд шилжүүлсүгэй.

2. Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажиллах төлөвлөгөөг нэгдүгээр, Ажлын тусгай горимыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан төвийн түр хоноглох байранд байрлаж буй иргэдийг зайлшгүй шаардлагатай тохиолдолд гарах хөдөлгөөнийг зөвшөөрч, халдвар хамгааллын дэглэм сахиулан хяналт тавин ажиллахыг нийт ажилтнуудад анхааруулсугай.

4. Уг тушаалаар Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/25 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА  Г.ЦЭРЭНДУЛАМ



318060330



Нийгмийн хамгааллын тусгай төвийн даргын
 2020 оны 12 сарын 17 ны өдрийн
 Ажлын дугаартай тусгаарлагчийн 1 дүгээр хэвсрэлт

**НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВӨӨС КОВИД-19 ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ӨНДӨРЖҮҮЛСЭН БЭЛЭН БАЙДЛЫН
 ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2020 оны 12 дугаар сарын 17

Улаанбаатар хот

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах нэгж, ажилтны нэр	Хамтран ажиллах байгууллага
1	2	3	4	5
УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ				
1	"Маскаа зүүцээг- гараа угаая" аяны хэрэгжилтийг үргэлжлүүлэх	XII-31 хүртэл	Эмч, нийгмийн ажилтнууд	-
2	Шаардлагатай тохиолдолд иргэдийг албан ёсны зөвшөөрлөөр гаргах	Өдөр бүр	Нийгмийн ажилтан, хариуцлагатай жижүүр	-
3	Халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлэх, гаднаас ирсэн иргэд албаны хүмүүсийн хөдөлгөөний маршрутыг мэдээлэх чиглэлээр QR код уншуулах	Өдөр бүр	Нийт ажилтнууд	-
4	Өрөө тасалгааны болон гадна орчны цэвэрлэгээ, агаар сэлгэлт, ариутгал халдваргүйжүүлэлт тогтмол хийх, хяналт тавих	Өдөр бүр	Эмч, үйлчлэгч, хариуцлагатай жижүүр	-
5	Шаардлагатай эм, ариутгал халдваргүйтгэлийн бодис, хэрэгслийн хангалт хийх, мэргэжлийн байгууллагаар ариутгал хийлгэх	-	Эмч, Нягтлан бодогч, нярав	НЭМГ, Шинэ ариусал ХХК
9	Иргэд болон ажилтнуудад дархлаа дэмжих аарц, чацаргана өгөх		Нягтлан бодогч, нярав, тогооч нар	
10	Иргэдэд өдөр тутмын мэдээллийг өрөө өрөөнд нь зохион байгуулах		Хариуцлагатай жижүүр, эмч	

11	Мэдээ тайланг тогтоосон хугацаанд холбогдох дээд байгууллагуудад хүргүүлэх Гаднаас ирсэн иргэдийн оношлогоо хэрхэн хийлгэх талаар дээд газраас чиглэл зөвлөмж авах		Бичиг хэргийн ажилтан	
			Дарга	НЗДТГ, НЭМГ
НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР				
2	Шинээр ирж буй иргэн бүрийг түргэвчилсэн оношлуураар шинжилгээнд хамруулах, оношлуур тест олгоход удирдлагаар хангах		Мэргэжлийн удирдлагаар хангах зөвлөгөө	-



Нийгмийн хамгаалын тусгай төвийн даргын
 2020 оны 6 сарын 2-ны өдрийн
 №156 дугаартай тушаалын 2 дугаар хавсралт

ӨНДӨРЖҮҮЛСЭН БЭЛЭН БАЙДЛЫН ҮЕД АЖИЛЛАХ ТУСГАЙ ГОРИМ

1. Нийт ажилтан албан хаагчид Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллах
2. Халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиж, иргэдэд тавих хяналтыг тогтмолжуулах

Үүнд:

- 2.1. Иргэдийн гарах орох хөдөлгөөнийг хяналттайгаар зохицуулан, удирдлагыг мэдээллээр ханган ажиллах
- 2.2. Өглөө, оройд / мөн шаардлагатай үед / иргэдийн халууныг тогтмол хэмжиж, тэмдэглэл хөтлөх, сэжигтэй тохиолдлыг тусгаарлах, мэдээлэх арга хэмжээг хэрэгжүүлэх
- 2.3. Хоёр цаг тутамд иргэдийн гарыг угаалгаж, амны хаалтыг угааж индүүдүүлэх
- 2.4. Өрөө тасалгаа, гадна орчны цэвэрлэгээ, ариутгалыг тухай бүр чанартай хийж, тогтмол хяналт тавин ажиллах
- 2.5. Иргэдийг 3-4 ээлжээр хооллох, гэрт шинээр байрласан иргэдэд хоолыг нь зөөж өгөх
3. Гаднаас өөрийн хүсэлтээр болон цагдаагийн албан хаагчийн шаардлагын дагуу ирсэн иргэдийг тусгаарлах дэгийг сахиулан гэрт байрлуулах
- 3.1. Иргэний халууныг хэмжиж, асуумж авч, эмчид үзүүлж шийдвэрлэх
4. Дархлаа дэмжих халуун шингэн зүйл уулгах, аарц, чацаргана, ганганы ханд нэмэлтээр олгох
5. Өдрийн хоолны дараа 2 цаг унтаж амрах дэглэм тогтоох